



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн "Хонгор сумын хот тохижилт" ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр

Утас: 89275858

Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 181

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хонгор сумын хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хонгор сумын төвийн автозам болон явган хүний замыг 1,656,032.8 мянган төгрөгөөр сайжруулан, барьж байгуулсныг хүлээн авч санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 62 хувьтай тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	278,701,994.47	167,514,752.77
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,991,857.77	7,655,30.00
3	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,991,857.77	7,655,230.00
4	31210	Төгрөг	142,991,857.77	7,655,230.00
5	31213	Арилжааны банк дахь харилцах	142,991,857.77	7,655,230.00
6	33	АВЛАГА	25,828,340.00	39,415,790.00
7	33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	22,533,390.00
8	33401	Дансны авлага /Г ӨҮГ/	25,828,340.00	16,882,400.00
9	35	БАРАА МАТЕРИАЛ	109,881,796.70	120,443,732.77
10	35400	Хангамжийн материал	109,881,796.70	120,443,32.77
11	35410	Бичиг хэргийн материал	514,500.00	335,500.00
12	35420	Аж ахуйн материал	33,925,500.00	32,437,923.50
13	35430	Сэлбэг хэрэгсэл	1,620,000.00	5,595,040.00
14	35440	Түлш, шатах тослох материал	700,000.00	700,000.00
15	35450	Барилгын засварын материал	2,635,000.00	57,040,395.79
16	35470	Бусад хангамжийн материал	70,486,796.70	24, 334, 873.48
17	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,225,156,917.05	3,010,365,220.29
18	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,25,156,917.05	3,010,365,220.29
19	39200	Биет хөрөнгө	1,224,240,250.33	3,007,748,553.53
20	39201	Барилга, байгууламж, орон сууц	-	46,715,000.00
21	39203	Авто-т эзврийн хэрэгсэл	259,706,900.00	621,906,900.00
22	39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,020,779.08)	(117,759,481.88)
23	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	133,119,900.00	133,119,900.00
24	39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,441,155.30)	(113,062,899.98)
25	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,941,940.00	19,941,940.00
26	39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,830,405.14)	(5,822,246.65)
27	39209	Зам, гүүрийн байгууламж	147,702,062.40	147,702,062.40
28	39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(29,540,412.48)
29	39214	Бусад үндсэн хөрөнгө	1,288,240,910.01	3,017,493,972.01
30	39215	Хуримтлагдсан элэгдэл	(460,179,122.56)	(712,946,179.89)
31	39300	Биет бус хөрөнгө	916,666.72	2,616,666.76
32	39301	Програм хангамж	1,650,000.00	3,900,000.00
33	39302	Хуримтлагдсан элэгдэл	(733,333.28)	(1,283,333.24)
34	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,503,858,911.52	3,177,879,973.06
35	4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,902,750.00	13,808,834.00

36	41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,902,750.00	13,808,834.00
37	41300	Өглөг	10,902,750.00	13,808,834.00
38	41360	Бусад өглөг	10,902,750.00	13,808,834.00
39	41366	Дансны өглөг /Т ӨҮГ/	10,902,750.00	13,808,834.00
40	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,492,956,161.52	3,164,071,139.06
41	51	Засгийн газрын хувь оролцоо	1,492,956,161.52	3,164,071,139.06
42	51106	Эздийн өмчийн бусад хэсэг /Т ӨҮГ/	1,650,063,266.64	3,781,231,328.64
43	51200	Хуримтлагдсан үр дүн	(157,107,105.12)	(617,160,189.58)
44	51210	Өмнөх үеийн үр дүн	55,946,549.59	(157,107,105.12)
45	51220	Тайлант үеийн үр дүн	(213,053,654.71)	(460,053,084.46)
46	6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,503,858,911.52	3, 177,879,973.06

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	458,642,650.00	354,303,417.00
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	458,642,650.00	354,303,417.00
3	120	Нийтлэг татварын бус орлого	458,642,650.00	354,303,417.00
4	120009	Бусад орлого	411,201,500.00	255,000,000.00
5	120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /Г ӨҮГ/	47,441,150.00	66,303,417.00
6	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	33,000,000.00
7	210811	Ерөнхий ба удирдлагын зардал /Г ӨҮГ/	619,858,146.10	811,887,126.46
8	210813	Бусад зардал /Г ӨҮГ/	51,838,158.61	2,469,375.00
9	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)	(213,053,654.71)	(460,053,084.46)
10	VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(213,053,654.71)	(460,053,084.46)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
			1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-н зэрх үлдэгдэл	792,872,715.43	-	55,946,549.59	848,819,265.02
2	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	792,872,715.43	-	55,946,549.59	848,819,265.02
3	5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	857,190,551.21	-	-	857,190,551.21
4	9	Тайлант үеийн үр дүн	-	-	(213,053,654.71)	(213,053,654.71)
5	10	2024 оны 12-р сарын 31-н зэрх үлдэгдэл	1,650,063,266.64	-	(157,107,105.12)	1,492,956,161.52
6	11	2025 оны 1-р сарын 1-н зэрх үлдэгдэл	1,650,063,266.64	-	(157,107,105.12)	1,492,956,161.52
7	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,650,063,266.64	-	(157,107,105.12)	1,492,956,161.52
8	15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,131,168,062	-	-	2,131,168,062
9	19	Тайлант үеийн үр дүн	-	-	(460,053,084.46)	(460,053,084.46)
10	20	2025 оны 12-р сарын 31-н аарх үлдэгдэл	3,781,231,328.64	-	(617,160,189.58)	3,164,071,139.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	466,284,450.00	277,466,833.22
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	466,284,450.00	277,466,833.22
3	120	Нийтлэг татварын бус орлого	466,284,450.00	277,466,833.22
4	120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	55,082,950.00	22,466,833.22
5	120017	Татаас, санхүүжилтийн орлого /Т ӨҮГ/	411,201,500.00	255,000,000.00
6	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,781,184.07	412,803,460.99
7	21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,781,184.07	412,803,460.99
8	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,781,184.07	412,803,460.99
9	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,015,444.11	303,507,347.29
10	210106	Ажилагчдад төлсөн /Т ӨҮГ/	235,015,444.11	303,507,347.29
11	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,251,144.46	41,379,763.70
12	210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /Т ӨҮГ/	29,251,144.46	41,379,763.70
13	2104	Хангамж, бараа материалын зардал	19,448,500.00	24,290,000.00
14	210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /Т ӨҮГ/	12,628,400.00	24,290,000.00
15	210410	Бараа материал худалдан авахад төлсөн /Т ӨҮГ/	6,820,100.00	-
16	210816	Татварын байгууллагад төлсөн /Т ӨҮГ/	-	43,626,350.00
17	210818	Бусад мөнгөн зарлага /Т ӨҮГ/	43,066,095.50	-
18	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)- (II)	139,503,265.93	(135,336,627.77)
19	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	139,503,265.93	(135,336,627.77)
20	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,488,591.84	142,991,857.77
21	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,991,857.77	7,655,230.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Зардлын нэр	2025 он			
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
ОРЛОГО					
1	Үйл ажиллагааны орлого	124,063,300.00	66,303,417.00	(57,759,883.00)	53
2	Орон нутгийн төсвөөс	300,000,000.00	255,000,000.00	(45,000,000.00)	85
3	Бусад орлого	-	33,000,000.00	(33,000,000.00)	-
4	Урд оны үлдэгдлээс	142,991,800.00	-	(142,991,800.00)	-
	ОРЛОГЫН ДҮН	567,055,100.00	354,303,417.00	(212,751,683.00)	62
1	НИЙТ ЗАРДАЛ				
2	Цалин хөлс ба нэмэгдэл урамшуулал	378,993,200.00	337,095,450.00	(41,897,750.00)	89
3	Хангамж бараа материалын зардал	71,213,100.00	29,044,582.50	(28,973,369.40)	41
4	Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж	7,081,000.00	87,590,668.45	80,509,668.45	123
5	Бусад зардал	7,800,000.00	2,279,900.00	(5,520,100.00)	29
6	Элэгдлийн зардал	101,967,800.00	358,345,900.51	(256,378,100.51)	351
	БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ	567,055,100.00	814,356,501.46	247,301,401.46	144
	АШИГ, АЛДАГДАЛ	-	(460,053,084.46)	(135,336,627.77)	-

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж нийт 174,074.4 мянган төгрөгийн залруулга илрүүлж, санхүүгийн тайланг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан ба 487.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна. Аудитаар хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	487.6	1	487.6	100
Нийт дүн	1	487.6	1	487.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 174,074.4 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Завсрын аудитаар үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хагас жилийн санхүүгийн тайлантай тулган шалгахад 174,074.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул татварын бүртгэлийн тайлангийн алдааг залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Мөн аудитаар нийт 4,204.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогдоогүй.

5.3 Зөвлөмж

5.3.1. Ээлжийн амралтын цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ээлжийн амралтын нэг өдрийн дундаж цалинг тооцохдоо ажилтанд сар бүр олгодог 3,564.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг оруулан тооцоолж ээлжийн амралтын цалинг бодож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 тоот тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 3.3-д “Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын нэг өдрийн дундаж цалинг тооцохдоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/191 дүгээр тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

5.3.2. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгөөр 640.0 мянган төгрөгийн бялуу худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад 174,074.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсан.	1	174,074.4	1	174,074.4	-	-	1	174,074.4	-	-	-	-
Дүн	1	174,074.4	1	174,074.4	-	-	1	174,074.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эзлжийн амралтын нэг өдрийн дундаж цалинг тооцохдоо ажилтанд сар бүр олгодог хоолны мөнгийг оруулан тооцоолж эзлжийн амралтын цалинг бодож олгосон байна.	1	3,564.0	-	-	-	-	1	3,564.0	-	-	-	-

Дүн	1	3,564.0	-	-	-	1	3,564.0	-	-
-----	---	---------	---	---	---	---	---------	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1	640.0	-	-	-	-	640.0
Байгууллагын хөрөнгөөр 640.0 мянган төгрөгийн бялуу худалдан авсан.	1	640.0	-	-	-	-	640.0
Дүн							

